



ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ БАЙГУУЛЛАГЫН 2023 ОНЫ ХЭРЭГЛЭГЧИЙН ҮНЭЛГЭЭ

УЛААНБААТАР ХОТ
2023 ОН

АГУУЛГА

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

УДИРТГАЛ

БҮЛЭГ 1. ҮНЭЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙ

1.1 Судалгааны үндэслэл.....	8
1.2 Зорилго, зорилт.....	8
1.3 Хамрах хүрээ, түүврийн хэмжээ, түүвэрлэлт.....	8-9
1.4 Судалгааны арга зүй.....	9-11
1.5 Мэдээлэл цуглуулалт, боловсруулалт.....	12-13

БҮЛЭГ 2. ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН

2.1 Судалгаанд оролцогчдын ерөнхий мэдээлэл.....	14-15
2.2 Үйлчилгээний чанар, найдвартай үр дүнтэй байдал ...	12-22
2.3 Үйлчилгээний хүртээмж, ил тод байдал.....	23-27
2.4 Албан хаагчийн харилцааны соёл, ёс зүй, авилгад өртөх байдал.....	27-31
2.5 Үйлчилгээ үзүүлж буй орчин нөхцөлийн тав тухтай байдал, шаардлагатай техник, тоног төхөөрөмжийн хангамж хүрэлцээ.....	31-32

ДҮГНЭЛТ БА ЗӨВЛӨМЖ

ХАВСРАЛТ

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Судалгааны арга зүй, дараалал

Хүснэгт 2. Иргэд, олон нийтийн хандлагын судалгаа

Хүснэгт 3. Үнэлгээний тайлан боловсруулах дараалал

Хүснэгт 4. Хорих ял эдлүүлэх ажиллагаа

Хүснэгт 5. Ил тод байдлын шалгуур

Хүснэгт 6. Тодорхойлолт авах зааварчилгаа



ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Судалгааны түүвэрлэлт, хамрах хүрээ

Зураг 2. Судлагдах агуулгын ерөнхий дараалал


Зураг 3. Судалгаанд оролцогчдын хүйсийн харьцаа

Зураг 4. 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөгөөр дэвшүүлсэн зорилтууд

Зураг 5. Гадаад харилцаа, хамтын ажиллагаа

Зураг 6. Ил тод байдлын үнэлгээ

Зураг 7. Байгууллагын самбарт байршуулсан нээлттэй мэдээлэл



ГРАФИКИИН ЖАГСААЛТ

- График 1. Судалгаанд оролцогчдын насны ангилал
- График 2. Судалгаанд оролцогчдын боловсролын байдал
- График 3. Судалгаанд оролцогчдын боловсролын байдал
- График 4. Үйлчилгээний чанар, найдвартай байдал
- График 5. Үйлчилгээний чанар, найдвартай байдал
/Хорих , 409, 415, 429 дүгээр анги/
- График 6. Цалингийн нэмэгдлийг шийдвэрлэсэн байдал
- График 7. Нийгмийн асуудлыг шийдвэрлэсэн байдал
- График 8. Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагаа
- График 9. Шийдвэр гүйцэтгэх ажиллагаа
- График 10. Үйлчилгээний хүртээмж
- График 11. Иргэдийн мэдээлэл авч буй эх сурвалж, хувиар
- График 12. Алба хаагчийн харилцааны соёл, ёс зүйн үзүүлэлтүүд, тэдгээрийн дундаж үнэлгээ
- График 13. Алба хаагчийн албан ажил дахь харилцааны байдал
- График 14. Алба хаагчийн авилгын эрсдэлд өртөх байдал
- График 15. Байгууллагын орчин нөхцөл, тав тухын үзүүлэлтүүд, тэдгээрийн дундаж үнэлгээ
- График 16. Албан хаагчдын мэдлэг, ур чадварын дундаж үнэлгээ
- График 17. Авсан үйлчилгээний сэтгэл ханамжийн байдал
- График 18. Үйл ажиллагааны үнэлгээ
- График 19. Үйлчилгээний чанар, хүртээмжийн үнэлгээний үзүүлэлтүүд, тэдгээрийн дундаж үнэлгээ

УДИРТГАЛ

Хууль зүй, дотоод хэргийн яам, харьяа агентлаг, байгууллага нь чиг үүргийн дагуу иргэд, байгууллагад үйлчилгээ үзүүлэхдээ Үндсэн хуульд заасан төрийн үйл ажиллагааны үндсэн зарчмыг баримтлан хүний эрх, шударга ёс, тэгш байдлыг ханган ажиллах үүрэг хүлээдэг.

Монгол Улсын Их Хурлаас хөгжлийн бодлого төлөвлөлтийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийг 2020 онд шинэчлэн баталж мөрдүүлсэнтэй холбоотойгоор Засгийн газраас хөгжлийн бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах явц, үр дүнд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, төрийн захиргааны байгууллагын үйл ажиллагааны үр дүнг үнэлж дүгнэхтэй холбогдсон харилцааг зохицуулан журамласан.

Журамд төрийн захиргааны байгууллагууд жил бүр үзүүлж буй үйлчилгээний чанар хүртээмжийн талаар иргэдээс сэтгэл ханамжийн судалгаа авах ажлыг хөндлөнгийн байгууллагаар хийлгэхээр тусгасан нь дэлхийн улс орнуудын Засгийн газрын нэгэн адил сайн засаглал, хариуцлага, ил тод байдал, хөгжлийн илүү үр дүнд хүрэх, бодит үр дүнг бий болгох талаар оролцогч талуудаас тавьж буй шахалт шаардлагад мэдрэмжтэй хандах болсны тод илрэл юм.

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-д хэрэглэгчийн үнэлгээг хийхдээ Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2017 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 302 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Хэрэглэгчийн үнэлгээний ерөнхий удирдамж”-ийг удирдлага болгохыг заасан.

Иймд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хуулиар хүлээсэн чиг үүргийн хүрээнд үзүүлж буй үйлчилгээ чанартай, хүртээмжтэй, хүнд сурталгүй шуурхай байгаа эсэх талаар иргэдийн хандлагыг тандан судлах, түүнд дүн шинжилгээ хийж, цаашид хэрэгжүүлэх бодлого, үйл ажиллагаанд зөвлөмж гарган ажиллалаа.

Энэ ажлыг гүйцэтгэхэд зохион байгуулалтын дэмжлэг үзүүлсэн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн дарга, дэд хурандаа С.Дэлгэрзаяа болон тус хэлтсийн алба хаагчдад талархалаа илэрхийлье.

БҮЛЭГ 1. ҮНЭЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙ

1.1. СУДАЛГААНЫ ҮНДЭСЛЭЛ

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам” (цаашид “нийтлэг журам” гэх), Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2022 оны 107 дугаар тушаалаар баталсан “Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын 2017 оны 302 дугаар тушаалаар баталсан “Хэрэглэгчийн үнэлгээний ерөнхий удирдамж”, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газартай байгуулсан ажил гүйцэтгэх 01 дугаартай гэрээ, “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын 2023 оны хэрэглэгчийн үнэлгээ хийх ажлын удирдамж”-ыг тус тус үндэслэл болгов.

1.2. ЗОРИЛГО, ЗОРИЛТ

Ажлын зорилго нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас үзүүлж буй үйлчилгээний чанар, хүртээмж, шуурхай байдалд үнэлгээ хийж, цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагаа, бодлого төлөвлөлтийг сайжруулахад чиглэнэ.

Зорилгынхоо хүрээнд дараах зорилтыг тодорхойлж үнэлгээ хийв. Үүнд:

- Бодлого, үйл ажиллагаа иргэдэд хүрсэн байдлыг үнэлэх;
- Цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааны талаар иргэдийн саналыг авах, судлах;
- Иргэдээс авсан санал асуулгын дүнд үндэслэн үзүүлэх үйлчилгээ сайжруулах зөвлөмж өгөх.

1.3. ХАМРАХ ХҮРЭЭ, ТҮҮВЭРЛЭЛТ

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа 409 дүгээр хаалттай хорих анги, 415 дугаар нээлттэй, хаалттай хорих анги болон 429 дүгээр хаалттай хорих анги-Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэгийн үйл ажиллагааг хамруулах удирдамжийн дор тус ажлыг гүйцэтгэв.

Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүрэг дэх Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа 429 дүгээр хаалттай хорих анги, Баянзүрх дүүрэг дэх 409 дүгээр анги, Төв аймгийн Баян сум дахь 415 дугаар хаалттай хорих анги, Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газраар үйлчлүүлж буй иргэд, алба хаагчдыг хамарсан нийт 384 хүнээс судалгааг авч, үр дүнг гаргалаа.

4. Үйлчилгээ үзүүлж буй орчин нөхцөлийн тав тухтай байдал, шаардлагатай техник, тоног төхөөрөмжийн хангамж хүрэлцээ.

Зураг 2. Судлагдах агуулгын ерөнхий дараалал



Судалгааны баг уг ажлын судалгаанд хэрэглэгдэх арга зүй, дараалал, түүврийн дизайныг захиалагч байгууллагын удирдамжид тохируулан боловсуулж, үр дүнгийн нэгтгэл, оролцогчдын мэдээлэл, SPSS өгөгдөл зэргийг “Оюуны цэлмэлт” төрийн бус байгууллагын зөвлөх, доктор, профессорын удирдлага дор боловсруулан дараах үйл ажиллагааны зураглалын дагуу ажиллалаа.

Хүснэгт 1. Судалгааны арга зүй, дараалал



хүснэгт 2. иргэд, олон ниитийн хандлагын судалгаа



Хүснэгт 3. Үнэлгээний тайлан боловсруулах дараалал



1.5 МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАЛТ, БОЛОВСРУУЛАЛТ

Улаанбаатар хот болон Төв аймагт санал асуулгын аргаар нийт 384 судалгаанд хамрагдагчаас анхдагч мэдээлэл, 12 хамрагдагчаас чанарыг нэмэгдүүлэх зорилгоор ганцаарчилсан ярилцлага, иргэн, алба хаагчийн төлөөллөөс бүрдсэн 2 фокус бүлгийн ярилцлага авсан.

Судлаачдад үнэлгээ судалгааны зорилгыг танилцуулж, санал асуулгыг хэрхэн бөглөх, асуултуудыг хэрхэн ойлгох талаар арга зүйн зааварчлагаа өгч, судалгааг явуулсан.

Тоон судалгааны мэдээлэл цуглуулах ажлыг мөн тус бүр 2 гишүүнтэй 2 баг, 4 хүний бүрэлдэхүүнтэйгээр шалгуур хангасан иргэнээс санал асуулгыг судлаач нэг бүрчлэн асууж, бөглөх зарчмаар хийж гүйцэтгэсэн.

Чанарын судалгааны мэдээллийг ганцаарчилсан болон фокус бүлгийн ярилцлагын аргыг ашиглаж цуглуулсан.

Мэдээлэл боловсруулахдаа мэдээллийг шалган кодлолт хийн оруулж, “Зах зээлийн, олон нийтийн санаа бодол, нийгмийн судалгаа, нэр томъёоны тайлбар толь, үйлчилгээнд тавигдах шаардлага” MNS ISO 20252:2012 олон улсын стандартын дагуу зохих хяналт хийсэн.

“Оюуны цэлмэлт” НҮТББ нь судалгаа хийх бүхий л техник, программ хангамж, хүний нөөцийн чадамжтай бөгөөд судалгааны үе шатанд ёс зүй, мэргэжлийн чиг баримжаатай байж, Олон Улсын судалгааны стандартыг мөрдөн ажилладаг байгууллага юм.

Хэрэглэгчийн үнэлгээний судалгааг нарийвчлан авч үзвэл дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна.


- Судалгааны түүвэрлэлтийг шинжлэх ухааны үндэслэлтэй арга зүйн дагуу хийх;
- Судалгааны түүврийн хамрах хүрээг иргэд болон аж ахуйн нэгж, байгууллагын шаардлагатай түүврийн хэмжээг тодорхойлох;
- Байгууллагаар үйлчлүүлж буй хэрэглэгчдийн сэтгэл ханамжийн судалгааны асуулгыг холбогдох стандартын дагуу боловсруулах;
- Батлагдсан асуулгыг мэргэжлийн программд оруулах, шалгах программыг бэлтгэх, турших;
- Судалгааны мэдээлэл цуглуулалтыг зохион байгуулах, мэдээлэл цуглуулалтыг зохион байгуулахдаа CAPI (Computer Assisted Personal Interview) аргаар зорилтот хэрэглэгчээс нүүр тулсан ярилцлагын аргаар мэдээлэл цуглуулах;
- Мэдээлэл цуглуулалтыг MMCG компанийн бэлтгэгдсэн, туршлагатай судлаачдын тусламжтайгаар мэргэжлийн өндөр түвшинд хяналтыг ажлыг

хиих. Үүнд: Судалгааны дата мэдээллийг аудио бичлэгтэй тулгах, түүврийн тархалтыг Real Time байдлаар GPS-ээр хянах, сэтгэл ханамж, хүндрэл бэрхшээлийн талаар дүн шинжилгээ хийх;

- Цуглагдсан өгөгдлүүдийг нэгтгэх, үр дүнгийн хүснэгтүүдийг гарган авах, мэдээлэлд дүн шинжилгээ хийх, судалгааны үр дүнгийн тайлан боловсруулах;
- Судалгааны эцсийн тайланг захиалагч талд танилцуулж хэлэлцүүлэг зохион байгуулах.

Ажил гүйцэтгэхэд дараах зарчмыг баримтласан. Үүнд:

- Хөндлөнгийн хараат бус байх;
- Шинжлэх ухааны үндэслэлтэй арга зүйг ашиглах;
- Үнэлгээнд оролцогчдын мэдээллийн нууцлалыг хадгалах;
- Бүх ойлголт, тодорхойлолтууд оролцогч талуудад (тухайлбал, асуулга боловсруулагчид, мэдээлэл цуглуулагчид болон мэдээлэлд дүн шинжилгээ хийх ажилтнууд) ойлгомжтой, тодорхой байх;
- Цуглуулсан мэдээлэл нь зорилгодоо нийцсэн, үнэн зөв байх;
- Үр дүн, тайлан нь тодорхой, ойлгомжтой, бодлого боловсруулахад хэрэглэгдэхүйц байх зэрэг болно.




БҮЛЭГ 2. ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН

2.1 СУДАЛГААНД ОРОЛЦОГЧДЫН ТАЛААРХ ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ


Санал асуулгад нийт 384 иргэн хамрагдснаас 95.0 хувь нь Улаанбаатар хотоос, 5.0 хувь нь Төв аймгаас хамрагдсан. Хүйсийн хувьд оролцогчдын 273 нь буюу 71 хувь нь эрэгтэйчүүд, харин 111 нь буюу 29 хувь нь эмэгтэйчүүд байв.

Зураг 3. Судалгаанд оролцогчдын хүйсийн харьцаа



Судалгаанд оролцогч нийт 384 хүний насыг ангилан авч үзвэл 24 наснаас доош ангилалд хамаарах 39, 25-34 насны ангилалд хамаарах 69, 35-44 насны ангилалд хамаарах 180, 45-54 насны ангилалд хамаарах 58, 55 наснаас дээш насны ангилалд хамаарах 38 хүн тус тус байна.

График 1. Судалгаанд оролцогчдын насны ангилал



2.2 ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, НАЙДВАРТАЙ БАЙДАЛ

2.2.1. Үйлчилгээний чанар, найдвартай байдал

Судалгаанд оролцсон иргэдээс Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйлчилгээний чанарыг үнэлүүлж, дүнг багцлан нэгтгэлээ. Ингэхдээ 1 оноо - Маш муу, 2 оноо □ Муу, 3 оноо □ Дунд зэрэг, 4 оноо □ Сайн, 5 оноо □ Маш сайн гэсэн байдлаар үнэлүүлэн дундаж утгыг тооцон гаргалаа.

График 4. Үйлчилгээний чанар, найдвартай байдал



Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын иргэдэд үзүүлэх үйлчилгээний чанар, найдвартай байдлыг тодорхойлох үүднээс нийт 5 асуулт бүхий асуулгыг 384 иргэнээс авч үр дүнг нэгтгэлээ. Ингэхдээ үр дүнг (**Маш муу, Муу, Дунд зэрэг, Сайн, Маш сайн**) нэгтгэн гаргахад дараах байдалтай байна. Үүнд:

- Тус байгууллагын ажилтны хариуцлагатай байдал ямар байсан бэ? гэсэн асуултад тод цэнхэрээр дүрсэлсэн үр дүн гарсан буюу маш муу-62, муу-60, дунд зэрэг-66, сайн-72, маш сайн-61 гэж хариулсан бол мэдэхгүй гэж 63 хүн хариулжээ.

- Ажилтны шударга байдал ямар байсан бэ? гэсэн асуултад тод шараар дүрсэлсэн үр дүн гарсан буюу маш муу-23, муу-26, дунд зэрэг-118, сайн-96, маш сайн-93 гэж хариулсан бол мэдэхгүй гэж 28 хүн хариулжээ. Энэ нь байгууллагын албан хаагчдын шударга байдалд сэтгэл өндөр байгааг илэрхийлж байна.

- Ажилтны боловсрол, мэдлэг ямар байсан бэ? гэсэн асуултад тод ногооноор дүрсэлсэн үр дүн гарсан буюу маш муу-32, муу-24, дунд зэрэг-131, сайн-120, маш сайн-67 гэж хариулсан бол мэдэхгүй гэж 10 хүн хариулжээ. Энэ нь ажилтны боловсрол, мэдлэгт сэтгэл өндөр байгааг илэрхийлж байна.

-Тантай эелдэг таатай харилцсан уу? гэсэн асуултад улбар шараар дүрсэлсэн үр дүн гарсан буюу маш муу-14, муу-69, дунд зэрэг-188, сайн-49, маш сайн-35 гэж хариулсан бол мэдэхгүй гэж 10 хүн хариулжээ. Энэ нь байгууллагын албан хаагчдын харилцаа хандлагад дунд зэрэг сэтгэл ханамжтай байгааг илэрхийлж байна.

- Танд бусадтай адил ижил тэгш үйлчилсэн үү? гэсэн асуултад улаанаар дүрсэлсэн үр дүн гарсан буюу маш муу-21, муу-11, дунд зэрэг-99, сайн-128, маш сайн-113 гэж хариулсан бол мэдэхгүй гэж 13 хүн хариулжээ. Энэ нь байгууллагын албан хаагчдын шударга байдалд сэтгэл өндөр байгааг илэрхийлж байна.

График 5. Үйлчилгээний чанар, найдвартай байдал /Хорих , 409, 415, 429 дүгээр анги/



Дээрх байдлаар үйлчилгээний чанар, найдвартай, үр дүнтэй байдлыг ажилтнуудын хариуцлагатай байдал, шударга байдал, адил тэгш үйлчилсэн байдал, ажилтнуудын харилцаа, боловсрол мэдлэг гэсэн дэд агуулгын хүрээнд үнэлүүлэхэд **дундаж үнэлгээ нь 4.74** гэж дүгнэгдлээ.

2.2.2. Үйлчилгээний үр дүнтэй байдал

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас иргэдэд үзүүлэх үйлчилгээний үр дүнтэй байдлыг үнэлэхдээ хуулиар хүлээсэн чиг үүргийнхээ хүрээнд хийж гүйцэтгэсэн ажлуудыг авч үзэн, дүн шинжилгээ хийсэн.

Тус байгууллага нь хорих ял эдлүүлэх, хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх, шийдвэр гүйцэтгэх ажиллагааны гэсэн үндсэн чиг үүргүүдийн хүрээнд болон

захиргааны чиглэлээр холбогдох хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ бүрэн хэрэгжүүлэн ажиллаж байна.

Байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд дараах зорилтуудыг дэвшүүлэн хэрэгжилтийг ханган ажиллажээ.

Зураг 4. 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөгөөр дэвшүүлсэн зорилтууд



Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас тайлант онд хэрэгжүүлсэн онцлох ажлыг тус үнэлгээний тайланд оруулах нь зүйтэй гэж судалгааны баг үзэж дараах байдлаар хүргэж байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар нь хүний нөөцийн удирдлагын үйл ажиллагааг оновчтой болгох, ажлын ачааллыг тэнцвэржүүлэх зорилгоор ахлагч бүрэлдэхүүнийг албан тушаалд томилох, цэргийн цол олгох эрхийг харьяа алба, хорих анги, шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэс, салбар нэгжийн дарга нарт шилжүүлэн ажиллажээ.

Алба хаагчдын үндсэн цалин болон нэмэгдлүүдийг нэмэгдүүлэх саналыг Хууль зүй, дотоод хэргийн яам, Сангийн яаманд уламжлан, шийдвэрлүүлж Засгийн газрын тогтоол, Хууль зүй, дотоод хэргийн сайдын тушаалаар алба хаагчдын цалинг нэмэгдүүлснээр нийт цалинг өмнөх оны мөн үетэй харьцуулахад офицер бүрэлдэхүүний цалин 44 хувь, ахлагч бүрэлдэхүүний цалин 48 хувиар тус тус өссөн таатай үзүүлэлттэй байна.

2023 оноос хүүхэд асрах чөлөөтэй байгаа алба хаагчдад цолны цалинг олгуулахаар тооцож, өнөөдрийн байдлаар 210 алба хаагчид олгожээ.

График 6. Цалингийн нэмэгдлийг шийдвэрлэсэн байдал



Эх сурвалж: (Байгууллагын даргаас нийт бие бүрэлдэхүүн болон иргэд, олон нийтэд хүргэсэн тайлангаас ишлэв.)

Алба хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх хүрээнд 269 алба хаагчид хөнгөлөлттэй үнээр орон сууц, 21 алба хаагч, ахмад ажилтнуудад гэр олгож, тусламж дэмжлэг үзүүлсэн байна.

Аймаг, нийслэлийн төвөөс бусад сум, алслагдсан газарт таван жил тасралтгүй ажилласан алба хаагчид 30 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшуулал олгох ажлыг эхлүүлсэн. Өнөөдрийн байдлаар 349 алба хаагчид олгосон байна.

График 7. Нийгмийн асуудлыг шийдвэрлэсэн байдал



Автомашинын парк шинэчлэлтийн ажлын хүрээнд 31 автомашиныг харьяа анги, байгууллага, салбар нэгжид олгожээ.

Гадаад хамтын ажиллагаагаа өргөжүүлэх хүрээнд гадаад улсын ижил чиг үүрэг бүхий байгууллагуудын үйл ажиллагаатай танилцан, харилцан туршлага судлах зорилгоор Их Британи, Австрали, Гүрж, БНСУ, Чех, Япон, Тайланд, Канад, Вьетнам, БНХАУ зэрэг улстай хамтран ажилласан байна.

Зураг 5. Гадаад харилцаа, хамтын ажиллагаа



Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд оролцогчдын эрхийг хангах, хамгаалах, баривчлах, цагдан хорих, хорих ял эдлүүлэх үйл ажиллагаанаас үүдсэн хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хүний эрхэд суурилсан хандлагыг төлөвшүүлэх ажлын хүрээнд Монголын Өмгөөлөгчдийн холбоотой хамтран ажиллах санамж бичиг байгуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Алба хаагчид болон тэдний гэр бүлийн гишүүдийг эмчилгээ, эмнэлгийн үзлэгт хамрагдахад хөнгөлөлт үзүүлэх зорилгоор Бүгд Найрамдах Солонгос Улсын "Эль" эмнэлэгтэй хамтран ажиллах гэрээ байгуулжээ.

Мөн алба хаагчдыг төлөвлөгөөт урьдчилан сэргийлэх эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд хамруулах, яаралтай тусламж болон 3 дугаар шатлалын эмнэлгийн тусламж шаардлагатай тохиолдолд шат дараатайгаар үйлчлүүлэх, мэргэшүүлэх, давтан сургалт зохион байгуулах, хоригдол, хоригдогсдод эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх чиглэлээр Улсын нэгдүгээр төв эмнэлэгтэй хамтран ажилласан байна.

ниитэд тустаи ажил хиилгэх ялын үр нөлөөг дээшлүүлэх зорилгоор энэ төрлийн ял шийтгүүлсэн этгээдүүдээр нийслэл хотын өнгө үзэмжийг сайжруулах, иргэдэд ээлтэй орчныг бүрдүүлэх ажлыг үе шаттайгаар зохион байгуулж, тодорхой үр дүнд хүрсэн байна.

Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны бодит биелэлтийг нэмэгдүүлэх, алба хаагчдын ажлын ачааллыг тэнцвэржүүлэх, иргэдэд төрийн үйлчилгээг шуурхай, хүртээмжтэй хүргэх зорилгоор үе шаттай арга хэмжээг хэрэгжүүлсний үр дүнд гүйцэтгэх баримт бичгийн бодит биелэлт 49.6 хувь, мөнгөн дүнгийн биелэлт 18.8 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеэс 4.4 хувиар өссөн дүнтэй байгаа талаарх мэдээллийг тус тус хүргэжээ.

2023 оны хагас жилийн байдлаар Хорих ял эдлүүлэх ажиллагааны чиглэлээр дараах ажил, арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласан байна.

Хүснэгт 4. Хорих ял эдлүүлэх ажиллагаа



2023 оны хагас жилийн байдлаар Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагааны чиглэлээр дараах ажил, арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласан байна.

График 8. хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагаа



2023 оны хагас жилийн байдлаар Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны чиглэлээр дараах ажил, арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласан байна.

График 9. Шийдвэр гүйцэтгэх ажиллагаа



Уг дэд үзүүлэлтийн хүрээнд үйлчилгээний үр дүнтэй байдлыг үнэлэхдээ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хуулиар хүлээсэн чиг үүргээ үр дүнтэй

хийж хэрэгжүүлсэн баидалд үнэлэлт дүгнэлт өгөхөд чиглэлээ. Байгууллагын хэмжээнд 2023 онд ажилтан албан хаагчдын цалин урамшуулал, нийгмийн байдлыг дээшлүүлэхэд анхаарч, үндсэн чиг үүргийн хүрээнд хийж хэрэгжүүлсэн ажлын статистик үр дүн дээшилсэн зэрэг үзүүлэлтүүдэд үндэслэн **5.0 үнэлгээг** өгсөн болно.

Үйлчилгээний чанар, найдвартай, үр дүнтэй байдлын үнэлгээ 4.84 оноо $((4.77+5.0)/2)$ -той дүгнэгдлээ.

2.3. ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРТЭЭМЖ, ИЛ ТОД БАЙДАЛ

2.3.1. Үйлчилгээний хүртээмжтэй байдал

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын иргэдэд үзүүлэх үйлчилгээний хүртээмжтэй байдлыг тодорхойлох үүднээс нийт 7 асуулт бүхий асуулгыг 384 иргэнээс авч үр дүнг нэгтгэлээ. Ингэхдээ үр дүнг *(Маш муу+Муу; Дунд зэрэг, Сайн+Маш сайн)* 3 утгаар авч үзэн гаргахад дараах байдалтай байна. Үүнд:

-Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаар үйлчлүүлэхэд хэр хэцүү байна вэ? гэсэн асуултад 35 нь тааруу үнэлгээ өгсөн бол 145 нь дунд зэрэг 204 нь сайн үнэлгээ өгсөн байна.

-Тус байгууллагын ажиллах өдөр/цаг нь танд хэр тохиромжтой байдаг вэ? гэсэн асуултад 13 нь тааруу үнэлгээ өгсөн бол 178 нь дунд зэрэг 178 нь сайн, харин 15 нь мэдэхгүй гэж хариулжээ.

-Өндөр настан/хөгжлийн бэрхшээлтэй иргэд энд үйлчлүүлэхэд хэр тохиромжтой байна вэ? гэсэн асуултад 10 нь сэтгэл дундуур, 207 нь зорилтот бүлгийн иргэд үйлчилгээ авахад боломжийн 144 нь сэтгэл ханамжтай байгаага илэрхийлсэн. Харин 23 нь мэдэхгүй гэж хариулсан байна.


-Иргэний авч буй үйлчилгээг утас, интернет, ТҮЦ машин ашиглан авах боломж байсан уу? Гэсэн асуултад 69 нь боломжгүй байсан, 176 нь дунд зэрэг 126 нь боломжийн, харин 13 нь мэдэхгүй гэжээ.

-Авч буй үйлчилгээний талаарх мэдээлэл хангалттай байсан уу? Гэсэн асуултад 100 нь хангалттай байгаагүй, 116 нь дунд зэрэг, 157 нь хангалттай сайн байгааг, харин 11 нь мэдэхгүй гэжээ.

-Ямар материал бүрдүүлэх нь ойлгомжтой байсан уу? Гэсэн асуултад 33 нь ойлгомжгүй, 163 нь дунд зэрэг, 187 нь ойлгомжтой байсаныг илэрхийлж, харин 1 оролцогч мэдэхгүй гэжээ.

-Ажилтнуудын тоо хүрэлцээтэй байсан уу? Асуултад 23 нь хүрэлцээ муу, 93 нь дунд зэрэг, харин 200 нь хүрэлцээтэй сайн байгааг илэрхийлж, 68 нь сайн мэдэхгүй байна гэжээ.

График 10. Үйлчилгээний хүртээмж



Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын олон нийттэй харилцах болон мэдээлэл сурталчилгааны ажлын байдлыг нэг талаас олон нийтийн мэдээллийн хэрэгцээ, хайлтаар тодорхойлж болох бол нөгөө талаас Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ил тод байдал, хэвлэл мэдээллийн хэрэгслийг үйл ажиллагаандаа ашиглаж буй байдлыг харж болно.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагатай холбоотой мэдээлэл авч буй эх сурвалж

Иргэдийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагатай холбоотой мэдээллийг ямар эх сурвалжаар голлон авч байгаа болохыг дараах зургаар дэлгэрүүлэн харууллаа.

График 11. Иргэдийн мэдээлэл авч буй эх сурвалж, хувиар



Иргэдийн ихэвчлэн мэдээлэл авахыг хүсэж буй эх сурвалжаар интернет, телевиз гэсэн мэдээллийн эх сурвалжууд нэрлэгдэж байна. Энэ нь мэдээлэл ихэвчлэн авдаг болон авахыг хүсэж буй сувгууд хоорондоо шууд хамааралтай байгааг илтгэж буй тул эдгээр мэдээлэл түгээх эх сурвалжуудыг түлхүү ашиглах нь үр дүнтэй.

Дээрх дүрсээс харахад иргэд одоогийн нөхцөлд утасны мессеж болон лавлах утсаар мэдээлэл аваад байдаггүй ч цаашид авах сонирхолтой байгаагаа илэрхийлсэн хувь өссөн байна. Мэдээлэл авдаг хэлбэр болон авахыг хүссэн эх сурвалжуудыг үзүүлж буй үйлчилгээ болон байгууллагаар харьцуулахад статистикийн хувьд ач холбогдол бүхий ялгаа ажиглагдахгүй байна.

Үйлчилгээний хүртээмжийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаар үйлчлүүлэхэд гарч буй хүндрэл, ажлын цагийн тохиромжтой байдал, зорилтот бүлгийн иргэдэд үйлчлүүлэх орчин нөхцөл бүрдсэн байдал, үйлчилгээний талаарх мэдээлэл хангалттай, ойлгомжтой байсан эсэх, албан хаагчдын тоо хүрэлцэж байгаа эсэх зэрэг асуудлын хүрээнд судалгаа хийж, **дундаж үнэлгээг 4.7 байна гэж нэгтгэн гаргалаа.**

2.3.2. Үйлчилгээний ил тод байдлын үнэлгээ

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 352 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журам”-ыг удирдлага болгон байууллагын нээлттэй мэдээллийг цахим хэлбэрээр байршуулах, нийтлэх, шинэчлэх байдлын хэрэгжилтийг судлав.

“Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журам”-д заасан дараах шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлгээ өгсөн байна.

Хүснэгт 5. Ил тод байдлын шалгуур

БАЙГУУЛЛАГЫН ИЛ ТОД БАЙДЛЫГ ҮНЭЛСЭН ШАЛГУУР

ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

-Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8.8-д заасны дагуу олон нийтэд мэдээлсэн эсэх


-Нээлттэй мэдээллийг хуулийн 8.9, 8.11-д заасан зохицуулалтын хүрээнд бүрэн гүйцэд тусгасан эсэх

-Нээлттэй мэдээллийг хуулийн 8.2-8.6-д заасан зохицуулалтын хүрээнд бүрэн гүйцэд тусгасан эсэх

-Эх сурвалжийн тодорхой байдал-хуулийн нээлттэй мэдээллийг дэлгэрүүлж авах, тодруулах эх сурвалж, холбоо барих мэдээллийг цахим хуудсанд байршуулсан эсэх

Ийнхүү үнэлэхэд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар нь 2023 оны 11 дүгээр сарын 21-ны өдрийн байдлаар 100%-ийн үнэлгээтэй дүгнэгдсэн байна.

Зураг 6. Ил тод байдлын үнэлгээ



Эх сурвалж: Shilen.gov.mn цахим сан. 2023.11.21-ний өдөр

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас иргэдэд үзүүлдэг лавлагаа тодорхойлолтыг авах зааварчилгааг мэдээллийн цахим сайтаар дараах байдлаар мөн мэдээлэн төрийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулан ажиллаж байна.

Хүснэгт 6. Тодорхойлолт авах зааварчилгаа

ТОДОРХОЙЛОЛТ, ЛАВЛАГАА ХҮСЭГЧ ЮУГ АНХААРАХ ВЭ?	ШҮҮХИЙН ШИЙДВЭРЭЭР ТОГТООСОН ТӨЛБӨРТЭЙ ЭСЭХ ТОДОРХОЙЛОЛТ	ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЦАХИМ МАШИНААР ЛАВЛАГАА ОЛГОХ										
<div style="background-color: #4a90e2; color: white; text-align: center; padding: 5px; margin-bottom: 5px;">ИРГЭН</div> <ul style="list-style-type: none"> - Иргэний үнэмлэх, түүний хуурбар болон төрийн үйлчилгээний цахим машинаас олгосон иргэний бүртгэлийн лавлагаа, гадаад улсын иргэний паспорт - Төлөөлөгчөөр дамжуулж тодорхойлолт хүсч байгаа тохиолдолд тухайн иргэнд олгосон итгэмжлэл - Хураамж төлсөн баримт <div style="background-color: #4a90e2; color: white; text-align: center; padding: 5px; margin-bottom: 5px;">ХУУЛИЙН ЭТГЭЭД</div> <ul style="list-style-type: none"> - Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар - Хуулийн этгээдийн хүсэлт, төлөөлөгчөөр дамжуулж тодорхойлолт хүсч байгаа бол итгэмжлэл - Хураамж төлсөн баримт <div style="background-color: #f4a460; color: white; text-align: center; padding: 5px; margin-bottom: 5px;">ЛАВЛАГАА, ТОДОРХОЙЛОЛТЫН ХУРААМЖИЙГ</div> <p>БАНК: ГОЛКОМТ БАНК НСР: ШШГЕГ-Шийдвэр гүйцэтгэх газар ДАНС: 1405132951 тоот данс.</p> <div style="background-color: #4a90e2; color: white; padding: 5px;"> <p>Төрийн эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас хэрэг, маргаан хянан шийдвэрлэх ажиллагаатай холбогдуулан иргэн, хуулийн этгээд шүүхийн шийдвэрээр тогтоосон төлбөртэй эсэх талаар мэдээлэл хүссэн тохиолдолд лавлагааг төлбөргүй олгоно.</p> </div>	<p>Шийдвэр гүйцэтгэх алба нь шүүхийн шийдвэрээр тогтоосон мөнгөн төлбөрийн үүргийг биелүүлээгүй этгээдийн талаар төлбөртэй этгээдийн бүртгэл хөтлөх, улсын хэмжээнд нэгдсэн бүртгэлийн сан үүсгэх, хүсэлт гаргасан этгээдэд тодорхойлолт, лавлагаа олгох чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна.</p> <ol style="list-style-type: none"> 1 Шийдвэр гүйцэтгэх албанаас хүсэлт гаргасан иргэн, хуулийн этгээдэд мөнгөөр. 2 Банкнур дургуйн Дундговьгаар төв "Төрийн үйлчилгээний нэгдсэн төв"-д хүсэлт гаргасан иргэн, хуулийн этгээдэд мөнгөөр. 3 Хүсэлт гаргасан иргэнд ТҮЦ машинаар, хамтгүйн ажиллах газруудтай байгууллагад цахим хэлбэрээр. 4 Орон нутагт шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэст хүсэлт гаргасан иргэн, хуулийн этгээдэд мөнгөөр. <table border="1" style="width: 100%; border-collapse: collapse; margin-top: 10px;"> <thead> <tr> <th style="background-color: #4a90e2; color: white;">Лавлагаа олгох буй төлбөр</th> <th style="background-color: #4a90e2; color: white;">Байршил</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>Шийдвэр гүйцэтгэх алба</td> <td>Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг 10 дугаар хороо, Цагдаагийн гудамж 43/1-ийн 8 өвөр</td> </tr> <tr> <td>Төрийн үйлчилгээний нэгдсэн төв</td> <td>Банкнур дургуй 26 дугаар хороо "Пүнжингарга" худалдааны төв</td> </tr> <tr> <td>ТҮЦ машина</td> <td>Орон нутагт 31, нийслэлд 76 цэгт олгож байна.</td> </tr> <tr> <td>Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэс</td> <td>21 аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар болон Сэлэнгэ аймгийн Мандал сум дахь ШШГ Хэлтэс, Сэлэнгэ аймгийн Сайхан сум, Дорноговь аймгийн Завхан-Үүд сум дахь ШШГ Хэлтэс</td> </tr> </tbody> </table>	Лавлагаа олгох буй төлбөр	Байршил	Шийдвэр гүйцэтгэх алба	Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг 10 дугаар хороо, Цагдаагийн гудамж 43/1-ийн 8 өвөр	Төрийн үйлчилгээний нэгдсэн төв	Банкнур дургуй 26 дугаар хороо "Пүнжингарга" худалдааны төв	ТҮЦ машина	Орон нутагт 31, нийслэлд 76 цэгт олгож байна.	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэс	21 аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар болон Сэлэнгэ аймгийн Мандал сум дахь ШШГ Хэлтэс, Сэлэнгэ аймгийн Сайхан сум, Дорноговь аймгийн Завхан-Үүд сум дахь ШШГ Хэлтэс	<p>Төрийн үйлчилгээг иргэдэд шуурхай хүргэх чиглэлээр шүүхийн шийдвэрээр бусдад төлөх төлбөргүй талаарх тодорхойлолтыг ТҮЦ машинаас олгож байна.</p> <p>Иргэн тэ өвөг хамгийн ойр байрлах ТҮЦ машинаас шүүхийн шийдвэрээр төлбөргүй талаарх тодорхойлолтыг авах боломжтой.</p> <div style="text-align: center; margin-top: 10px;">  <div style="background-color: #4a90e2; color: white; padding: 5px; display: inline-block;"> ИРГЭН <ul style="list-style-type: none"> - Хуруучи хээг ившуулах - Иргэний үнэмлэх - Ваза карт /Бүр бөмб/ </div> </div> <div style="background-color: #76b82a; color: white; text-align: center; padding: 5px; margin-top: 10px;"> "Тодорхой.төлт"-ийн хураамжийг банкны ПОС машинаар хүлээн авч байна. </div> <div style="text-align: center; margin-top: 10px;">  </div>
Лавлагаа олгох буй төлбөр	Байршил											
Шийдвэр гүйцэтгэх алба	Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг 10 дугаар хороо, Цагдаагийн гудамж 43/1-ийн 8 өвөр											
Төрийн үйлчилгээний нэгдсэн төв	Банкнур дургуй 26 дугаар хороо "Пүнжингарга" худалдааны төв											
ТҮЦ машина	Орон нутагт 31, нийслэлд 76 цэгт олгож байна.											
Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэс	21 аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар болон Сэлэнгэ аймгийн Мандал сум дахь ШШГ Хэлтэс, Сэлэнгэ аймгийн Сайхан сум, Дорноговь аймгийн Завхан-Үүд сум дахь ШШГ Хэлтэс											

Зураг 7. Байгууллагын самоарт байршуулсан нээлттэй мэдээлэл



Дээрх зургаас байгууллагын хэмжээнд мэдээллийн ил тод байдлыг эрхэмлэн, авилгаас ангид байх, шударга ёсыг дээдлэн ажиллахын илэрхийлэл болгон мэдээллийн самбаруудыг байршуулдаг нь албан хаагчдыг соён гэгээрүүлэх, авилгын эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд чухал ач холбогдолтой юм.

Үйлчилгээний ил тод байдлын үнэлгээг *Shilen.gov.mn* цахим сан дахь үнэлгээ 100% буюу 5 оноогоор дүгнэсэн.

Үйлчилгээний хүртээмж, ил тод байдлын үнэлгээ 4.85 оноо ((4.7+5.0)/2)-той дүгнэгдлээ.

2.4. АЛБАН ХААГЧИЙН ХАРИЛЦААНЫ СОЁЛ, ЁС ЗҮЙ, АВИЛГАД ӨРТӨХ ЭРСДЭЛ

2.4.1. Албан хаагчийн харилцааны соёл, ёс зүй

Алба хаагчийн харилцааны соёл, ёс зүйг “Шударга байдал”, “Алба хаагчдын цаг баримтлах, ашиглах байдал”, “Ажилдаа хандах байдал”, “Бүх үйлчлүүлэгчидтэй ижил тэгш харилцах байдал”, “Ажилтнуудын эелдэг таатай харилцаа”, “Үйлчлүүлэгчид туслахад бэлэн байдал (хандлага)” гэсэн 6 үзүүлэлтээр үнэлүүлэхэд шударга байдлын дундаж үнэлгээ 4.3, алба хаагчдын цаг баримтлах, ашиглах байдлын дундаж үнэлгээ 4.2, ажилдаа хариуцлагатай хандах байдал, бүх үйлчлүүлэгчидтэй ижил тэгш харилцах байдал, ажилтнуудын эелдэг таатай харилцаа, үйлчлүүлэгчид туслахад бэлэн байдал гэсэн 4 дэд үзүүлэлтийн **дундаж үнэлгээ 4.4** байна.

График 12. Алба хаагчийн харилцааны соёл, ес зүйн үзүүлэлтүүд, тэдгээрийн дундаж үнэлгээ



Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын албан хаагч нь танд үйлчилгээ үзүүлэхдээ албаны нэрээр далайлган сүрдүүлэх, зүй бус харилцах тохиолдол гарсан уу гэх асуултад судалгаанд оролцогчдын 170 нь тийм, 93 нь үгүй гэж хариулсан байна.

График 16. Албан хаагчдын мэдлэг, ур чадварын дундаж үнэлгээ



График 17. Авсан үйлчилгээний сэтгэл ханамжин баидал



График 18. Үйл ажиллагааны үнэлгээ




График 13. Алба хаагчийн албан ажил дахь харилцааны байдал




Албан хаагчийн харилцаа, ёс зүйн талаар авсан судалгааны үр дүнгийн дундаж нь 4.4 оноогоор дүгнэгдсэн байна.

2.4.2. Албан хаагчийн авилгын эрсдэлд өртөх магадлал

Албан хаагчийн авилгын эрсдэлд өртөх магадлалыг иргэд үйлчлүүлэхдээ мөнгө төлсөн үү, хэрэв төлсөн бол ямар зориулалтаар төлсөн талаар асуухад судалгаанд оролцогчдын 8% нь үйлчилгээний үзүүлсэний төлөө төлбөр төлсөн, 47% нь бичиг баримтын татвар, мөнгөн хураамжийн төлбөр төлсөн, 18% нь бусад төлбөр төлсөн гэж хариулсан байна.

Төлсөн төлбөрийг үйлчилгээтэй харьцуулахад ямар байсан талаар асуухад боломжийн төлбөртэй байсан гэж 47% нь, бага төлбөртэй гэж 23% нь, их төлбөртэй гэж 30% нь хариулжээ.

График 14. Алба хаагчийн авилгын эрсдэлд өртөх байдал



Дээрх үр дүнгээс дүгнэхэд албан хаагчид авилгын эрсдэлд өртөх магадлал бага биш байгааг харуулж байна.

Гэвч Алба хаагчдын үндсэн цалин болон нэмэгдлүүдийг нэмэгдүүлэх саналыг Хууль зүй, дотоод хэргийн яам, Сангийн яаманд уламжлан, шийдвэрлүүлж Засгийн газрын тогтоол, Хууль зүй, дотоод хэргийн сайдын тушаалаар алба хаагчдын цалинг нэмэгдүүлснээр нийт цалинг өмнөх оны мөн үетэй харьцуулахад

офицер бүрэлдэхүүний цалин 44 хувь, ахлагч бүрэлдэхүүний цалин 48 хувиар тус тус нэмэгдүүлсэн нь авилгын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, энэ төрлийн эрсдэл гарахгүй байх магадлалыг дээшлүүлж байна.

Иймээс албан хаагчийн авилгын эрсдэлд өртөх магадлалыг тооцсон үнэлгээг 5.0 байх нь тохиромжтой гэж судалгааны баг үзлээ.

Албан хаагчийн ёс зүй, соёл, авилгын эрсдэлд өртөх байдлын үнэлгээ 4.7 оноо ((4.4+5.0)/2)-той дүгнэгдлээ.

2.5. ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЖ БУЙ ОРЧИН НӨХЦӨЛИЙН ТАВ ТУХТАЙ БАЙДАЛ, ШААРДЛАГАТАЙ ТЕХНИК, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ХАНГАМЖ ХҮРЭЛЦЭЭ

Байгууллагын орчин нөхцөл, тав тухыг “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй орчин бүрдүүлсэн байдал”, “Хүлээлгийн танхим дахь ширээ, сандлын хүртээмж”, “Үйлчилгээ авах хэсэгт үзгэн бал, маягт гэх мэт туслах зүйлсийн хүрэлцээт байдал”, “Байгууллагын гадна болон доторх тэмдэг, тэмдэглэгээний харагдахуйц ойлгомжтой байдал” гэсэн 4 үзүүлэлтээр үнэлүүлэхэд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй орчин бүрдүүлсэн болон үйлчилгээ авах хэсэгт үзгэн бал, маягт гэх мэт туслах зүйлсийн хүрэлцээт байдлын дундаж үнэлгээ тус бүр 4.6, хүлээлгийн танхим дахь ширээ, сандлын хүртээмжийн дундаж үнэлгээ 4.4, байгууллагын гадна болон доторх тэмдэг, тэмдэглэгээний харагдахуйц ойлгомжтой байдлын дундаж үнэлгээ 4.7 байна.

График 15. Байгууллагын орчин нөхцөл, тав тухын үзүүлэлтүүд, тэдгээрийн дундаж үнэлгээ



Дээрх зураглалаас харахад байгууллагын гадна болон доторх тэмдэг, тэмдэглэгээний харагдахуйц ойлгомжтой байдал нь байх ёстой түвшиндээ, харин хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй орчин бүрдүүлсэн байдал, хүлээлгийн танхим дахь ширээ, сандлын хүртээмж, үйлчилгээ авах хэсэгт үзгэн бал маягт зэрэг туслах зүйлсийн хүрэлцээтэй байдал зэрэг нь байх ёстой түвшиндээ хүрэхгүй байгааг харуулж байна.



ДҮГНЭЛТ

Үйлчилгээний чанартай байдлыг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас үйлчилгээ авсны дараагаар тухай бүрд нь авсан асуумж судалгааны үр дүнд тулгуурлан шинжилгээ хийсэн. Үйлчилгээний чанартай байдлыг мэдээллийн хангалттай байдал, ажилтнуудын тооны хүрэлцээтэй байдал, мэргэжлийн ур чадварын хангалттай байдал, төлбөр хураамжийн үйлчилгээтэй уялдаатай байдал зэргийг харгалзан үзэж үнэлсэн. Мөн ажиглалын арга, real time-аар хянах ажиллагааг хийлээ

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйлчилгээний чанар, хүртээмжийг “Үйлчилгээний чанар”, “Үйлчилгээний хүртээмж”, “Алба хаагчийн харилцааны соёл, ёс зүй, авилгад өртөх магадлал”, “Байгууллагын орчин нөхцөл, тав тух” гэсэн 4 гол үзүүлэлт тус бүрийн 4-6 дэд үзүүлэлтээр буюу нийт 19 дэд үзүүлэлтээр үнэлүүлж, нэгтгэн дүгнэхэд үйлчилгээний чанар, хүртээмж, сэтгэл ханамжийн үнэлгээний **НИЙТ ҮНЭЛГЭЭ НЬ 95.4% БУЮУ 4.77 ОНООТОЙ, ХАНГАЛТТАЙ САЙН** үзүүлэлттэй байна.

График 19. Үйлчилгээний чанар, хүртээмжийн үнэлгээний үзүүлэлтүүд, тэдгээрийн дундаж үнэлгээ



САНАЛ, ЗӨВЛӨМЖ

Судалгааны нийт дүн нь иргэдийн тухайн байгууллагын үйлчилгээний талаарх үнэлэмж тул зарим алба хаагч, иргэд, байгууллагатай хийсэн ярилцлага, баримт бичгийн судалгааны дүнд үндэслэн цаашид анхаарч ажиллах зарим санал, зөвлөмжийг өгч байна. Үүнд:

- Албан хаагчдын ажиллах орчин нөхцлийг сайжруулах, нийгмийн баталгааг хангах, дээшлүүлэх чиглэлээр албан хаагчдаас тавьж буй санал хүсэлт, шаардлага тухайлбал нийтлэг дурдагдаж буй ажлын дутуу орон тоог нөхөх, жишиг нормативд дүйцүүлэх, ажлын ачааллыг тодорхойлох, тусгай хэрэглэл, албан хэрэгцээний автомашинаар хангах гэх мэт хэрэгцээ шаардлагыг судалж үзэх;
 - Албан хаагчдын ёс зүй, харилцааны соёлыг дээшлүүлэх талаар тогтмол сургалт явуулах, байгууллагын үйлчилгээний стандартын хэрэгжилтийг хангах, хэрэгжилтэд үйлчлүүлэгчдээр болон хөндлөнгийн байгууллагаар тогтмол үнэлгээ, судалгаа хийлгэх;
 - Үзүүлж буй үйлчилгээтэй холбоотой шинэ дүрэм журам, тогтоол шийдвэрүүдийг тухай бүрд нь нийтэд мэдээлэх, үйлчилгээ авахад шаардагдах баримт бичгүүдийг ил тод болгох нь иргэд олон нийтэд хэрэгцээтэй байгааг анхаарах;
 - Байгууллагаас үзүүлж буй төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийн үр дүнг дээшлүүлэхийн тулд удирдах болон гүйцэтгэх албан тушаалтнуудын харилцаа хандлага, ёс зүйг сайжруулах, мөн хүний эрхийг дээдлэх, сайн засаглалыг бэхжүүлэхэд чиглэсэн сургалт, нөлөөллийн ажлыг зохион байгуулах, ингэхдээ үр дүнг тооцож, оновчтойг нь хэрэгжүүлэх;
 - Албан хаагчдын судалгааг <https://forms.gle/wqu9Wj9LrH9qqSti9> google doc-оор авч үр дүнг гаргахад дараах саналуудыг дэвшүүлсэн тул Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын удирдлагууд анхаарч ажиллах нь зүйтэй:
- Албан хаагчдын харилцаа, ёс зүйг сайжруулах талаар үр дүнтэй арга хэмжээг зохион байгуулах;
 - Ажлын ачааллыг жишиг нормативт хүргэн, орон тоог нэмэгдүүлж ажиллах;
 - Техник, тусгай хэрэгслийн хангамжийг нэмэгдүүлэх, автопаркын шинэчлэл хийх;

- Алба хаагчдыг чөлөөт цагаа зөв боловсон өнгөрөөх давуу талаа хөгжүүлэх боломжийг бүрдүүлэх, ээлжийн бүрэлдэхүүн гэж ялгавартай хандахгүй байх;
- ШШБ-ыг олон ниитэд сурталчлах;
- Ажилласан жил биш ажлын үзүүлэлтээр сурах боломж олгох;
- Хангалтын хувцасны материалыг сайжруулах;
- Хоригдол руу чиглэсэн арга хэмжээ авсаар алба хаагч руу чиглэсэн арга хэмжээ зохион байгуулагдахгүй байх, улмаар хоригдлууд алба хаагчаас илүү эрхтэй болж, алба хаагчийн эрх зөрчигдөөд байгааг анхаарах;
- Эм тарианы зардал болон эмнэлгийн тоног төхөөрөмж байгууллагын урсгал засварын зардлыг нэмэгдүүлэх;
- 30 сартай тэнцэх хэмжээний мөнгийг бүсчлэхгүй өгдөг байх.



Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тухай хууль, дүрэм журам мөрдүүлэх үйл ажиллагааны талаарх үнэлгээний хуудас

Эрхэм оролцогч Танаа!

Та санал асуулгад үнэн зөв хариулснаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагааг сайжруулахад бодитой хувь нэмэр оруулна гэдэгт итгэлтэй байна.

1. Таны хувийн мэдээлэл

Таны нас: , **хүйс:** эр, эм /зурна уу/

Таны боловсрол:

- бага дунд тусгай дунд дээд Бусад

Таны албан тушаал:

Та ШШГБ-д хэдэн жил ажиллаж байна вэ?

<input type="radio"/> 1 жил хүртэл	<input type="radio"/> 2-5 жил	<input type="radio"/> 10 жил	<input type="radio"/> 11-15 жил	<input type="radio"/> 16-20 жил	<input type="radio"/> 20-25 жил	<input type="radio"/> 26-аас дээш жил
------------------------------------	-------------------------------	------------------------------	---------------------------------	---------------------------------	---------------------------------	---------------------------------------

Та Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажиллах болсон шалтгаанаа сонгоно уу.

- A. Томилогдсон
 B. Өөрийн хүсэлтээр ажиллаж байгаа
 B. Олон жил ажилласан болохоор
 Г. Ерөнхий газрын шийдвэрээр түр хугацаанд ажлын байр сэлгэн ажиллаж байгаа
 Д. Түр хугацаанд хүний оронд ажиллаж байгаа
 E. Бусад

2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад мөрдөх дүрэм, журмын хэрэгжилтийн талаарх таны үнэлгээ. 1-3 баллаар үнэлнэ үү.

(1-муу буюу хангалтгүй, 2-дунд зэрэг, 3 –сайн буюу хангалттай)

№	үнэлгээ өгөх үзүүлэлт	Балл			Бусад /тайлбар, эсхүл мэдэхгүй гм/
1	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас иргэдэд үзүүлэх үйлчилгээ				
	Үйлчилгээний шуурхай, хүртээмжтэй байдал	1	2	3	
	Үйлчилгээний адил, тэгш байдал /ялгаварлан гадуурхах байдал үзүүлсэн эсэх/	1	2	3	
	Хүлээгдэл чирэгдэлгүй үйлчилдэг байдал	1	2	3	
	Боомт цагийн хуваарийн дагуу ажилладаг байдал	1	2	3	
	Алба хаагчдын мэндчилгээ, зан харьцаа, ёс зүйн байдал	1	2	3	
	Алба хаагчдын биеэ авч явах байдал, хувцаслалт	1	2	3	
	Мэдээллийг бүрэн, үнэн зөв өгөх байдал	1	2	3	
	Үйлчилгээний ажилтантай биечлэн уулзаж зөвлөгөө дэмжлэг авах боломж	1	2	3	
2	Үйлчилгээний орчин				
	Үйл ажиллагаа явуулах зориулалтын барилга байгууламж, заал, талбайн хүрэлцээ, нөхцөл, боломж	1	2	3	
	Хүлээлгийн танхимын ая тухтай байдал /сандлын хүрэлцээ, сонин, сэтгүүл гм/	1	2	3	
	Техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн хүрэлцээ	1	2	3	
	Дулаан, агааржуулалт, гэрэлтүүлгийн байдал	1	2	3	
	Бие засах газрын ариун цэвэр, үйлчилгээний байдал	1	2	3	

Мэдээллийн хүртээмж /мэдээллийн самбар, тараах материал, гарын авлага, зөвлөмжийн хүрэлцээ гм/	1	2	3	
Зарим үйлчилгээг өөрөө өөртөө үйлчлэх хэлбэрээр /ТҮЦ машин гм/ авах боломж	1	2	3	
интернет орчины хүрэлцээ, хүрд	1	2	3	
Борекс программын ажиллагаа	1	2	3	
Альа хаагчдын ажиллаж, амьдрах орчин, нөхцөл				
Орон баирны хангамж, хүрэлцээ	1	2	3	
Цалин хөлс олголт, хүртээмж	1	2	3	
Шагнал урамшууллын байдал, ил тод байдал	1	2	3	
Нийгмийн бусад үйлчилгээнд хамрагдах боломж /даатгал, банкны зээл, тэтгэмж тусламж гм/	1	2	3	
Дүрэмт хувцас, бусад хэрэглэлийн хангалт, чанар, хүртээмж	1	2	3	
Хоол хүнсний хангалт, чанар, хүртээмжтэй байдал /нэр төрөл/	1	2	3	
Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах боломж, нөхцөл	1	2	3	
Урах, мэдлэг, үр чадвараа дээшлүүлэх боломж, нөхцөл	1	2	3	
Цагаараа өөрийгөө хөгжүүлэх үйл ажиллагаа явуулах боломж, нөхцөл /фитнесс, төрөл бүрийн сургалт, соёл урлагийн үйлчилгээ, номын сан гм/	1	2	3	
Шинэ санаа, бүтээл гаргах боломж нөхцөл, дэмжлэгт байдал	1	2	3	
Тодорхой хугацаанд сайн ажилласан, туршлага хуримтлуулсан нөхцөлд тухайн чиглэлээр албан тушаал ахих, цол нэмэх боломж	1	2	3	
Үйл ажиллагаатай холбогдох асуудлаар санал хүсэлт гаргах, шаардлага тавьж, шийдвэрлүүлэх боломж, нөхцөл	1	2	3	

3. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад мөрдөх журмын хэрэгжилтийг ерөнхийд нь хэрхэн үнэлж байна вэ?

- 5 буюу маш сайн
 4 буюу сайн
 3 буюу дунд зэрэг
 2 буюу тааруу
 1 буюу хангалтгүй
 мэдэхгүй

4. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газруудын ажлын уялдаа холбоо, хамтран ажиллах байдлыг үнэлнэ үү.

- 5 буюу маш сайн
 4 буюу сайн
 3 буюу дунд зэрэг
 2 буюу тааруу
 1 буюу хангалтгүй
 мэдэхгүй

5. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад одоо байгаагаас нь сайжруулахад ямар арга хэмжээг авах хэрэгтэй гэж та үзэж байна вэ? Хамгийн чухал гэж үзсэн 3-4 арга хэмжээг дараалуулан бичнэ үү.

1.
.....
2.
.....
3.
.....
4.
.....

Санал асуулгад идэвхитэй оролцсон танд баярлалаа.
Танд ажлын амжилт хүсье. ☺

**НЭГ. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛЧИЛГЭЭНД
СЭТГЭЛ ХАНАМЖТАЙ БАЙДАЛ**

НЭГ. СУДАЛГААНД ОРОЛЦОГЧИЙН ТАЛААРХ ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

1.	Та хэдэн настай вэ?	Нас [. . . .]
2.	Таны хүйс:	1. Эрэгтэй 2. Эмэгтэй
3.	Таны албан боловсролын дээд түвшин ямар вэ? (Ж/нь дээд сургууль төгссөн хүн "Дээд" гэж хариулах)	1. Боловсролгүй 2. Бага /3/4 анги/ 3. Суурь /8/9 анги/ 4. Бүрэн дунд /10/11/12 анги/ 5. Техник болон мэргэжлийн дунд (МСҮТ) 6. Тусгай мэргэжлийн дунд (коллеж) 7. Дээд
4.	Таны ажил эрхэлдэг салбар	1. Ажилгүй 2. Төрийн байгууллага 3. Төрийн бус байгууллага 4. Олон улсын байгууллага 5. Хувийн хэвшил, компани 6. Хувиараа бизнес эрхэлдэг 7. Бусад

5. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь танд шаардлагатай үйлчилгээг үзүүлж чадсан уу?

1. Хангалттай сайн үзүүлдэг
2. Дунд зэрэг үйлчилгээ үзүүлдэг
3. Хангалтгүй муу байдаг
4. Сайн мэдэхгүй байна

6. Таны одоогийн авч буй үйлчилгээ бүрэн шийдвэрлэгдэж чадсан уу?

1. Бүрэн шийдвэрлэгдсэн
2. Хагас дутуу шийдвэрлэгдсэн. Шалтгаан:

.....

3. Огт шийдвэрлэгдээгүй. Шалтгаан:

.....

7. Одоогийн үйлчилгээг авахын тулд хэр хугацаа орсон бэ?

1. _____ цагийн дотор
2. _____ хоногийн дотор
3. Хэрэв шийдэгдээгүй бол үйлчилгээ авахаар анх хандсан хугацаа: _____

8. Үйлчилгээний хүртээмжтэй байдалтай холбоотой дараах асуултаудыг үнэлнэ үү?

№	Үнэлэх үзүүлэлтүүд	Маш муу	Муу	Дунд зэрэг	Сайн	Маш сайн	Мэдэхгүй
1.	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаар үйлчлүүлэхэд хэр хэцүү байна вэ?	1	2	3	4	5	
2.	Ажиллах өдөр/цаг нь танд хэр тохиромжтой байдаг вэ?	1	2	3	4	5	
3.	Өндөр настан/хөгжлийн бэрхшээлтэй иргэд энд үйлчлүүлэхэд хэр тохиромжтой байна вэ?	1	2	3	4	5	
4.	Тус үйлчилгээг утас, интернет, ТҮЦ машин ашиглан авах боломжтой байсан уу? талаарх мэдээлэл хангалттай байсан уу?	1	2	3	4	5	
5.	Ямар материал бүрдүүлэх нь ойлгомжтой байсан уу?						
6.	Ажилтнуудын тоо хүрэлцээтэй байсан уу?	1	2	3	4	5	
7.		1	2	3	4	5	

9. Та байгууллагын үйлчилгээний чанартай холбоотой дараах үзүүлэлтэд харгалзах үнэлгээг өгнө үү?

№	Үнэлэх үзүүлэлтүүд	Маш муу	Муу	Дунд зэрэг	Сайн	Маш сайн	Мэдэхгүй
1.	Танд бусадтай адил ижил тэгш үйлчилсэн үү?	1	2	3	4	5	
2.	Танд үйлчилгээг өгөхөд танд хэр хэцүү байсан бэ? Танд үйлчилгээг өгөхөд танд хэр хэцүү байсан бэ?	1	2	3	4	5	
3.	Ажилтны шударга байдал ямар байсан бэ?	5	4	3	2	1	
4.	Ажилтны хариуцлагатай байдал ямар байсан бэ?	5	4	3	2	1	
5.		5	4	3	2	1	

10. Одоогийн авч буй үйлчилгээг авахдаа мөнгө төлсөн үү? Тийм бол ямар зориулалтаар мөнгө төлсөн бэ?
1. Үйлчилгээний төлбөр (Үйлчилгээ үзүүлсний төлөө төлсөн төлбөр)
 2. Төлбөр, хураамж төлөх зорилгоор (бичиг баримтын татвар, мөнгөн хураамж)
 3. Бусад.....
 4. Төлж байгаагүй.
11. Хэрэв ямар нэгэн төлбөр хураамж төлсөн бол авсан үйлчилгээтэй харьцуулахад хэр боломжийн байсан бэ?
1. Их
 2. Боломжийн
 3. Бага
12. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагч нь танд үйлчилгээ үзүүлэхдээ албаны нэрээр далайлган сүрдүүлэх, зүй бус харилцах тохиолдол гарсан уу?
1. Тийм
 2. Үгүй
13. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагч нь танд үйлчилгээ үзүүлсэнийхээ төлөө шан харамж нэхэж байсан уу?
- 1.Тийм
 - 2.Үгүй
14. Танд шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас үзүүлж буй үйлчилгээг авахдаа тус байгууллагын албан хаагчдад өөрийн ашиг сонирхлоо гүйцэлдүүлэхийн тулд мөнгө болон бусад бэлэг дурсгалын зүйл өгөхийг санал болгож байсан удаа бий юу?
- 1.Тийм
 - 2.Үгүй
15. Одоогийн авч байгаа үйлчилгээтэй холбоотой ямар нэгэн санал гомдол байгаа эсэх?
1. Тийм. Ямар
.....
 2. Үгүй
.....
16. Та хүссэн үйлчилгээгээ авахын тулд нэг ажилтанд олон удаа хандах тохиолдол гарсан уу?
1. Тийм. /хэрэв тийм бол хэдэн удаа, яагаад?/
 2. Үгүй
17. Та энэ байгууллагаас үзүүлж буй үйлчилгээнд хэр сэтгэл хангалуун байна вэ?
1. Маш их сэтгэл ханамжтай
 2. Сэтгэл ханамжтай
 3. Дунд зэрэг
 4. Сэтгэл ханамжгүй
 5. Маш их сэтгэл ханамжгүй
18. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагаанд та ямар үнэлгээ өгөх вэ?
1. Маш сайн
 2. Сайн
 3. Дунд
 4. Муу
 5. Маш муу
19. САНАЛ ХҮСЭЛТ
-
-
-
-

Санал асуулгад идэвхитэй оролцсон танд баярлалаа.
Танд ажлын амжилт хүсье. ☺

